

**“ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгагдсан “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсрууллаа.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны чуулганы нэгдсэн хуралдаанаар Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийг хэлэлцэн баталж, 2017, 2021 онд тус нэмэлт, өөрчлөлт оруулсан юм.

Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын төсөв, санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулах арга хэмжээний хүрээнд Олон Улсын Валютын сангийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр (Stand by)-т хамрагдах нөхцөл, шаардлагыг хангах үүднээс холбогдох зарим хууль тогтоомжид өөрчлөлт оруулж, цэргийн алба хаагчийн цалин хэлс, нийгмийн хамгаалалтай холбоотой 3 эрх зүйн зохицуулалтыг өөрчилж, мөнгөн урамшуулалт олгох болон дээд офицерын цолны мөнгөтэй холбогдох 2 эрх зүйн зохицуулалтыг хүчингүй болгосон юм.

Тухайлбал, хуулийн 7 дугаар зүйлд заасан “улсын хил болон алслагдсанд тооцох анги, байгууллагад таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн застав болон түүнтэй адилтгах салбарт 50 хувь, суурин бус газар байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгохтой холбоотой зохицуулалтыг хүчингүй болгож, мөн хуулийн 9.5-д заасан дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгохтой холбогдсон зарим эрх зүйн зохицуулалтуудад өөрчлөлт оруулсан.

Хууль тогтоомжийн энэхүү эрх зүйн ялгавартай байдлаас шалтгаалан Зэвсэгт хүчний офицер, ахлагч нарын цалин хэлс, нийгмийн хамгаалал нь хуулиар харьцангуй илүү болох хилийн ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын болон цагдаагийн байгууллагад шилжин ажиллах хүсэл сонирхлыг бий болгож, алслагдсан болон хөдөө орон нутагт ажиллах хүсэл сонирхол илт буурч, жилээс жилд ажлаас чөлөөлөгдөх, өөр ажил, албан тушаалд шилжин явах тохиолдол ихсэх зэрэг сөрөг үр дагаврууд гарч байгаа нь Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Төрийн цэргийн байгууллагууд нь цэргийн эрх зүйн хэмжээ, цэргийн нийтлэг дүрмүүд, цэргийн цол, цэргийн алба хаагчийн бие бялдрын стандарт, энхийг дэмжих ажиллагаанд оролцох байдлаараа нэгдмэл байна” гэж заасантай зөрчилдэж, улмаар төрөөс тусгайлан бэлтгэгдсэн боловсон хүчний хүний нөөцийн хомсдол үүсэх нөхцөл нь хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг бий болгож байгаа юм.

Өнөөдөр Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулж хүчингүй болгосон эрх зүйн зохицуулалттай нэгэн адил зохицуулалтууд

Цагдаагийн албаны тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.10 дахь хэсэг, Монгол Улсын хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.7 дахь хэсэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 288 дугаар зүйлийн 288.6 дахь хэсэгт “Алслагдсан болон аймгийн төвөөс бусад суманд ажиллаж байгаа алба хаагч наарт мөнгөн урамшуулал олгох.” гэсэн зохицуулалтууд үйлчилж байгаатай Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 8.2-т “Төрийн цэргийн байгууллагууд нь цэргийн эрх зүйн хэм хэмжээ, цэргийн нийтлэг дүрмүүд, цэргийн цол, цэргийн алба хаагчийн бие бялдрын стандарт, энхийг дэмжих ажиллагаанд оролцох байдлаараа нэгдмэл байна” гэж заасантай нийцүүлэн хуульд холбогдох нэмэлт өөрчлөлт оруулсан болно.

“Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд дараах зарчмын өөрчлөлтүүдийг дурдвал:

-Алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарт тав ба түүнээс дээш жилийн хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид мөнгөн урамшуулал олгохтой холбогдсон;

-Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчдад цалин хөлс олгох журмыг холбогдох Засгийн газар гишүүн батлахтай холбогдсон;

-Улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцож байгаа цэргийн алба хаагчийн ажил, албан үүргийг хуулиар албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцох,

-Ажлын байрны бэлгийн дарамт шахалт үзүүлэх, ялгаварлан гадуурхахыг алба хаагчдын үйл ажиллагаанд хориглох зэрэг болно.

Хуулийн төсөл батлагдсанаар цэргийн алба хаагчийн нийгмийн баталгаа дээшилж, алслагдсан болон хөдөө, орон нутагт байрлах цэргийн анги, салбарт тогтвортой суурьшилтай ажиллах, цэргийн албаны хэвийн, аюулгүй, тасралтгүй үйл ажиллагаа хангагдах нөхцөл сайжирч, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого” баримт бичгийн “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6-д “Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.” гэсэн зорилт хангагдахад чухал нөлөө үзүүлж, хууль тогтоомжийн нийцэл хангагдах юм.

Хуулийн төслийг Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулсан бөгөөд 2024 оны улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй болно.

Иймд хуулийн төслийг хэлэлцэн, шийдвэрлэж өгнө үү.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

## “ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д батлан хамгаалах чиглэлээр “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулахаар заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг хамт өргөн мэдүүлэх бусад хуулийн төсөлтэй хамт боловсруулан танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны чуулганы нэгдсэн хуралдаанаар Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийг хэлэлцэн баталж, 2017, 2021 онд тус тус өөрчлөлт оруулжээ.

2017 онд Монгол Улсын төсөв, санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулах арга хэмжээний хүрээнд Олон Улсын Валютын сангийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр (Stand by)-т хамрагдах нөхцөл, шаардлагыг хангах үүднээс Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан цэргийн алба хаагчийн цалин хөлс, нийгмийн хамгаалалтай холбоотой 3 эрх зүйн зохицуулалтыг өөрчилж, 2 эрх зүйн зохицуулалтыг хүчингүй болгосон.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд тусгагдсан байсан “улсын хил болон алслагдсанд тооцох анги, байгууллагад таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн застав болон түүнтэй адилтгах салбарт 50 хувь, суурин бус газар байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгох.” гэсэн эрх зүйн зохицуулалтыг, мөн хуулийн “Цэргийн тэтгэвэр тогтоолгосон бэлтгэл, чөлөөнд байгаа дээд офицерт урьд эрхэлж байсан албан тушаалын цэргийн цолны цалинг харьялсан үндсэн байгууллага сар бүр олгох.” гэсэн зохицуулалтыг тус тус хүчингүй болгож, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчийн цалингийн хэмжээ, нэмэгдэл олгохтой холбогдсон зарим эрх зүйн зохицуулалтуудад холбогдох өөрчлөлтийг оруулсан нь цэргийн алба хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн хамгааллыг доройтуулж, тэр тусмаа хөдөө орон нутагт ажиллаж байгаа алба хаагчийн хувьд хот суурин газар луу шилжих, бусад давуу талыг хууль тогтоомжоор бий болгосон төрийн цэргийн байгууллагад ажиллах хүсэл сонирхол бий болох зэрэг сөрөг үр дагавар гарч байгааг таслан зогсоох, хууль тогтоомжид өөрчлөлт оруулан боловсронгуй болгох замаар цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг сайжруулах хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Мөн тус хуулийг баталснаас хойш эдүгээ 6 жилийн хугацаанд төрийн цэргийн болон хууль сахиулах зарим байгууллагууд өөр өөрийн хууль тогтоомжид алба хаагчийнхаа эрх зүйн байдал, ялангуяа алслагдсан болон хөдөө, орон нутагт ажиллаж байгаа алба хаагчдынхаа нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр эрх зүйн томоохон өөрчлөлтүүдийг оруулсан.

Тухайлбал, Цагдаагийн албаны тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.10 дахь хэсэг, Монгол Улсын хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.7 дахь хэсэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 288 дугаар зүйлийн 288.6 дахь хэсэгт “Алслагдсан болон аймгийн төвөөс бусад суманд ажиллаж байгаа алба хаагч наарт мөнгөн урамшуулал олгох.” гэсэн эрх зүйн зохицуулалтыг тус тус тусгаснаар тухайн байгууллагуудын алба хаагчийн эрх зүйн байдал сайжирч, албандаа итгэх итгэл, хандах хандлага, алба хаах хүсэл зориг, эрмэлзэл нь нэмэгдсэнээр алслагдсан болон хөдөө, орон нутагт ажиллах хүний нөөцийн чадавх нь сайжирсан байна.

Энэхүү эрх зүйн ялгавартай байдлаас шалтгаалан Зэвсэгт хүчний офицер, ахлагч нарын цалин хөлс, нийгмийн хамгаалал нь хуулиар харьцангуй илүү болох хилийн ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын болон цагдаагийн байгууллагад шилжин ажиллах хүсэл сонирхлыг бий болгож, алслагдсан болон хөдөө орон нутагт ажиллах хүсэл сонирхол илт буурч, жилээс жилд ажлаас чөлөөлөгдөх, өөр ажил, албан тушаалд шилжин явах тохиолдол ихсэх зэрэг сөрөг үр дагаврууд гарч, төрөөс тусгайлан бэлтгэгдсэн боловсон хүчний хүний нөөцийн хомсдол үүсэх нөхцөлийг бий болгож байна.

Өнөөдрийн байдлаар Зэвсэгт хүчний алслагдсан анги, салбарт болон хөдөө, орон нутагт алба хааж байгаа цэргийн алба хаагчдаас 2020 онд 250, 2021 онд 482, 2022 онд 674 цэргийн алба хаагч өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн, 67 цэргийн алба хаагч бусад төрийн цэргийн байгууллагад шилжсэн судалгаа байгаа нь эх орныхоо тусгаар тогтолц, бүрэн эрхт байдал, халдашгүй дархан байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах Зэвсэгт хүчний үндсэн чиг үүрэг алдагдах, хүний нөөцийн хомсдол үүсэх шалтгаан болж байгааг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар засаж сайжруулах зайлшгүй шаардлага үүсээд байгаа болно.

Монгол Улсын батлан хамгаалах салбар нь 39 улстай хамтын ажиллагаатай бөгөөд үүнээс одоогийн байдлаар 11 улсын цэргийн академи, их дээд сургуульд цэргийн алба хаагчийг суралцуулж байгаагаас жилд дунджаар тухайн улсын буцалтгүй тусламжаар жилд 98 орчим, хөнгөлөлттэй нөхцөлөөр 90 орчим, нийт 190 гаруй цэргийн алба хаагчийг суралцуулж байна.

Батлан хамгаалахын сайдын тушаалаар хоёр талын байгуулсан гэрээний онцлог, тухайн улсын гэрээний үүргээс хамааран ОХУ-д суралцаж байгаа цэргийн алба хаагчдад үндсэн цалинг 70 хувиар, БНХАУ, БНСУ, Польш Улсад суралцаж байгаа цэргийн алба хаагчдад үндсэн цалинг 50 хувиар, бусад улс орны цэргийн сургууль, коллежид суралцаж байгаа алба хаагчдад үндсэн цалинг 40 хувиар, дотооддоо суралцаж байгаа алба хаагч наарт үндсэн цалинг 100 хувиар тус тус тогтоон олгож байна.

Гэвч 2017 оны хуулийн өөрчлөлтөөр тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь “гадаадын цэргийн сургуульд суралцаж офицер, ахлагчийн суралцах хугацааны цалин хөлс, ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцах.” гэсэн зохицуулалтыг “гадаадын цэргийн сургуульд суралцаж офицер, ахлагчийн суралцах хугацааны сургалтын тэтгэлэг, ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцах.” гэж, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь “Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, сурагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал

эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах.” гэсэн зохицуулалтыг “Гадаадын цэргийн сургууль, академи, дамжаанд суралцагчийг сонгон шалгаруулах, сургалтын тэтгэлгийн хэмжээ, тэтгэлэг олгох журмыг Засгийн газар батална.” гэж тус тус өөрчилсөн.

Цэргийн алба хаагчийн цалин хөлснөөс хууль тогтоомжид заасны дагуу нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцдоггүйтэй холбоотойгоор цэргийн алба хаасан хугацааг түүний цалин, хөлс авч байсан баримтаар тодорхойлж, цэргийн тэтгэвэр тогтоолгоход алба хаасан жилийг баталгаажуулдаг.

Харин Дээд боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т “суралцагчийн тэтгэлэг” гэж дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн суралцах болон амьжиригааны зардлыг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг санхүүжүүлэхэд зориулан олгох буцалтгүй мөнгөн тусlamжийг” гэж зааснаар цаашдаа гадаадын цэргийн сургууль, академи, дамжаанд суралцсан хугацааг ажилласан жилд тооцохгүй байх нөхцөл үүсэхээр байгаа болно.

Цэргийн алба хаагчид гадаад, дотоодын цэргийн академи, их, дээд сургуульд 2-4 жилийн хугацаатай сурч байх хугацаанд цалин хөлс олгож байгаа асуудлыг Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7-д “төрийн хөрөнгөөр 6 хүртэлх сарын хугацаагаар давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдах, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалын цалинг авах” гэж, мөн хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2-т “зургаан сараас дээш хугацааны сургалтаар (шинэ дадлага, туршлага эзэмших сургалтыг оролцуулан) бэлтгэгдэх болсон;” гэсэн зохицуулалтад цэргийн алба хаагчийн гадаад, дотоодын цэргийн их, дээд сургуульд суралцаж байгаа хугацааг хамааруулж үзэх нь буруу ойлголт бөгөөд төрөөс манай улсад бэлтгэх боломжгүй мэргэжлээр цэргийн сургуульд суралцуулах болон академийн түвшний боловсрол олгохтой холбоотой асуудлыг “шинэ дадлага, туршлага эзэмших” гэсэн сургалтын хүрээнд авч үзэх боломжгүй юм.

Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т “Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлыг энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно” гэж заасны дагуу Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т “Энэ зүйлийн 4.2-т зааснаас гадна доор дурдсан нөхцөлийг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцно;” гэсний 4.3.2-т “гадаад, дотоодын цэргийн сургуульд суралцах” гэж зааснаар цэргийн алба хаагчийн гадаад, дотоодын цэргийн их, дээд сургуульд суралцаж буй хугацааг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцож, цалин хөлс авах эрх зүйн үндэс бүрдэж байгаа юм.

Хуулийн энэхүү зохицуулалтын хамрах хүрээнд тухайн оронтой байгуулсан гэрээний онцлогоос шалтгаалан Батлан хамгаалахын сайд болон холбогдох бусад сайд нарын тушаалаар зөвхөн тодорхой дотоод, гадаадын их, дээд сургуульд суралцагчдад ямар хэмжээний цалин хөлс олгохтой холбогдсон журмыг батлах эрхийг тусгаж өгснөөр цэргийн алба хаагчийн гадаад, дотоодын сургуульд суралцах хугацаа нь ажилласан жилд тооцогдож, цалин хөлснөөс эрүүл мэндийн даатгал төлөгдсөний үндсэн дээр цэргийн тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх зэрэг чухал ач холбогдолтой болно.

Иймд хуульд заасан “тэтгэлэг буюу буцалтгүй мөнгөн тусlamж” хэлбэрээр цалин хөлсийг орлуулан олгосон тохиолдолд цэргийн алба хаагчийн ажилласан жил, тэр тусмаа цэргийн алба хаасан хугацааг цэргийн тэтгэвэр тогтооход

тооцохгүй байх сөрөг үр дагавар гарах нөхцөлөөс сэргийлж хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байгаа болно.

Мөн хуулийн төсөлд 2019 онд Олон улсын Хөдөлмөрийн байгууллагаас Хүчирхийлэл, дарамтын тухай 190 дүгээр конвенцоор манай улсын хүлээсэн үүрэг, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон шинэчлэн баталсан Хөдөлмөрийн тухай хуулиар ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд аливаа дарамт шахалт, ялгаварлан гадуурхлаас ангид байхтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг цэргийн алба хаагчийн үүрэгт нэмж тусгаснаар гэмт хэргээс өөрийгөө болон нөхрөө хамгаалах, урьдчилан сэргийлэх өндөр ач холбогдолтой гэж үзэж холбогдох эрх зүйн зохицуулалтыг тусгах юм.

Түүнчлэн Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1.2-т “цэргийн алба хааж байгаагийн төлөө албан тушаалын ангиллын, алба хаасан хугацааны, цэргийн цолны мөнгөн хангамж эдлэх” гэж, Цагдаагийн албаны тухай хуулийн 87.9-д “Цагдаагийн алба хаагчийн цалин хөлс нь үндсэн цалин, цолны цалин болон доор дурдсан нэмэгдлээс бүрдэнэ.” гэсний 87.9.1-д “төрийн тусгай алба хаасан хугацааны” гэж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 287.8-д “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн цалин хөлс нь үндсэн цалин, цолны цалин болон доор дурдсан нэмэгдлээс бүрдэнэ:” гэсний 287.8.1-д “төрийн тусгай алба хаасан хугацааны” гэж тус тус заасан болон Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 2 дугаар “Зэвсэгт хүчин, хилийн цэргийн офицер, ахлагч нарт төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай” тогтоол зэрэгт нийцүүлэн хуулийн төслөөр Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2-т “удаан жил ажилласны” гэж заасныг “төрийн тусгай алба хаасан хугацааны” гэж өөрчлөхөөр тусгасан болно.

Иймд дээр дурдсан хууль зүйн болон практик хэрэгцээ, шаардлагын дагуу хуулийн төсөлд алслагдсан болон хөдөө орон нутагт үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн алба хаагчдын нийгмийн баталгааг дээшлүүлэх, албандаа итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор хүчингүй болсон зарим эрх зүйн зохицуулалтыг сэргээн бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсронгуй болгох, цэргийн алба хаагчийн гадаад, дотоодын цэргийн сургуульд суралцах хугацааны цалингийн хэмжээ, нэмэгдэл олгох журмыг эрх бүхий албан тушаалтан тогтоохтой холбогдох зохицуулалт болон шинэчлэн баталсан Хөдөлмөрийн тухай хууль, Олон улсын конвенцоор гишүүн орны хувьд хүлээсэн үүрэг, хариуцлагатай нийцүүлэн цэргийн алба хаагчийн эрх, үүрэгт тусгах зэрэг нэмэлт, өөрчлөлтийг оруулах юм.

Хуулийн төсөл батлагдсанаар цэргийн алба хаагчийн нийгмийн баталгаа дээшилж, алслагдсан болон хөдөө, орон нутагт байрлах цэргийн анги, салбарт тогтвортой суурьшилтай ажиллах, цэргийн албаны хэвийн, аюулгүй, тасралтгүй үйл ажиллагаа хангагдах нөхцөл сайжирч, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6-д “Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчинийг хөгжүүлнэ.” гэсэн зорилт хангагдаад чухал нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 3 дугаар зүйлийн 3.1, 38 дугаар зүйлийн 38.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох материалыг баримтжуулан хууль

тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргана.”, 38.5-д Олон нийтийн хэлэлцүүлгийг дараах хэлбэрээр явуулна: 38.5.3.санал асуулга явуулах, 38.5.4.олон нийтийн цахим сүлжээгээр хэлэлцүүлэг явуулах” гэж тус тус заасны дагуу төсөл болон холбогдох материалд олон нийтийн оролцоог хангах зорилгоор хуулийн төслийг холбогдох материалын хамт Батлан хамгаалах яамны цахим хуудас /mod.gov.mn/-т байршуулж, төрийн бус байгууллагаас саналыг авч тусгасан болно.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулсан бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Цэргийн албаны тухай хуульд тус тус нийцэж байгаа болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР